

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ЦӨМ ХӨТӨЛБӨРТ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА, АГУУЛГА, АРГА ЗҮЙ ТУСГАГДСАН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Ч.Нямгэрэл^{1*}, Н.Нэргүй², Э.Шинэцэцэг³, А.Туяа⁴

¹МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, *nyamgerel@num.edu.mn*

²Тэгш таван ухаан НҮТББ

³Байгаль орчны мэдээлэл сургалтын төв,

⁴МУБИС, Багшийн хөгжлийн төв

Хураангуй

Дэлхий нийтийн түвшинд боловсролын алсын хараа өөрчлөгдөж, сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжид ТХБ-ын үзэл санааг тусган хэрэгжүүлэх, ТХБ-той иргэний төлөвшилд онцгойлон анхаарч байна. Гэвч энэ нь амар, хялбар асуудал биш юм. Энэ судалгаагаар бид ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулгыг 3 багц 16 шалгуур 75 индикатораар үнэлэхдээ баримт бичгийн судалгааны арга зүйг хэрэглэлээ. Судалгааны үр дүнг ЕБС-д судалдаг бүх судлагдахууныг Математик, байгалийн ухаан, Хэл хүмүүнлэгийн ухаан, Түүх, нийгмийн ухаан, Сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэсэн 4 бүлэгт ангилж, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд ялгаж, сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүрээр боловсруулсан. Судалгаагаар давхардсан тоогоор 5653 өгөгдөл бүртгэгдсэнээс нийт өгөгдлийн 22.3% хөтөлбөрийн зорилго, зорилгод, 7.4% үнэлгээнд, 12.8% агуулгад, 33.1% аргад, 24.4% орчин ба хэрэглэгдэхүүнд тус тус ногдож байна. Сургалтын арга зүй буюу арга ба хэрэглэгдэхүүнд хамаарах өгөгдлүүд нийт өгөгдлийн 57.5% эзэлж, арга нь хэрэглэгдэхүүнээсээ 1.4 дахин олон бүртгэгдсэн. Энэ байдал нь үндэсний сургалтын цөм хөтөлбөрт арга зүйн хэсэг нь маш ерөнхий тусгагдсан байсан тул арга зүйн үнэлгээг илүү нарийвчлан тодруулах үүднээс үнэлгээнд Суралцахуйн удирдамжуудыг нэмж хамруулан үзсэнтэй холбоотой гэж үзэж болно. 2014 оноос эхлэн хүчин төгөлдөр

мөрдөж буй бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр бүхэлдээ шинжлэх ухааны мэдлэг, чадвараас гадна өөрийн хүч нөөцийг мэдрэх, бусадтай хамтрах, мэдлэгийг эрж хайх олж судлах арга барилтай болох, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, зорилго чиглэлтэй амьдарч хөдөлмөрлөх зэрэг хувь хүний хөгжилд хандсан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг харьцангуй сайн тусгаж чадсан байна.

Түлхүүр үгс: Тогтвортой хөгжил, Тогтвортой хөгжлийн зорилго, Тогтвортой байдлын цогц чадамж, Тогтвортой хөгжлийн боловсрол, Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (ТХЗБ), Сургалтын цөм хөтөлбөр.

Удиртгал

ЕБС-ийн сургалтад 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний хэмжээнд Бага, дунд боловсролын цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг мөрдөж, улмаар ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн шилжилтийн хөтөлбөрөөр дамжуулан хичээл тус бүрд ТХБ-ийг тусгах зорилтыг 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Мөн боловсролын салбарт 2012 оноос хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээнд хийгдсэн чанарын шинэчлэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж байдаг.

Монгол Улс, Монголын боловсролын салбар нь ТХ, ТХБ-ын түүхэн хөгжлийн үе шат бүрийн Дэлхий нийтийн шинэ санаачилга, үйл хэргийг анхааралтай ажиглаж, хөл нийлэхийн төлөө зүтгэж ирсэн. Үүний нэг жишээгээр УИХ-аас 2015 онд нийгэм, эдийн засаг, бизнес, улс орны бүхий л салбарын хөгжлийг урт хугацаанд баримжаалсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” болон БСШУ-ны Сайдын 2015 оны А/458 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага” бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Эдгээр баримт бичгүүд нь ерөнхий боловсролын сургалт,

үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, өөрчлөх ажлыг эрчимжүүлэх үйл явцыг дэмжсэн.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр 2015 оноос өнөөдрийг хүртэл үр дүнтэй хэрэгжиж байна. Цаашид цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйг бусад улс орнуудын нэгэн адилаар ЮНЕСКО-оос 2017 онд гаргасан “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” буюу “Education for Sustainable Development Goals” гэсэн баримт бичигт дэлгэрүүлэн тодорхойлсон тогтвортой хөгжлийг дэмжих суралцахуйн зорилтуудтай харьцуулан дүгнэж, уялдуулах эрэлт хэрэгцээ гарч байна.

Энэхүү судалгаагаар хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үнэлгээний гол зорилго нь бага, дунд боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрт тусгагдсан тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулгыг “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” баримт бичигт дурдсан суралцахуйн суралцахуйн зорилт, агуулгын сэдвүүд, арга зүйн хандлагатай харьцуулан дүгнэх, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг боловсруулахад оршино. Мөн дэлхий нийтээр боловсролын алсын хараа шинэчлэгдэж буй энэхүү эргэлтийн шинжтэй энэ цаг үед одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг дээрх үзэл баримтлалын үүднээс нягтлан судалж үндэсний болон салбарын түвшний мэргэжилтнүүдэд цэгцтэй, мэдээлэл өгөхөд дэмжлэг үзүүлэх зориулалттай.

Судалгааны арга зүй

Баримт судалгааны үндсэн арга (desk review)-ыг сонгосон тул баримт бичиг цуглуулж, түүнийг боловсруулах задлан шинжлэх, жиших, харьцуулах зэрэг танин мэдэхүйн барилууд болон компьютерын шаардлагатай программуудыг ашиглан судалгааны арга зүй, аргачлалыг боловсруулсан. Энэ судалгааг 2018 оны МУИС, БМДИ, БХ, МУБИС, БСШУЯ, “Тэгш таван ухаан боловсролын төв” НҮТББ, “Байгаль орчны мэдээлэл, сургалтын төв” НҮТББ, “Орхон хасу” сургууль, ТЗДС-ийг тус

тус төлөөлсөн 30 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэсэн бөгөөд нэгдсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж зөвлөх багаас дэд багийн ахлагчдад, дэд багийн ахлагчдаас гишүүдэд судалгааны арга зүй, аргачлалыг түгээн дэлгэрүүлэх, нэгтгэх “шаталсан” зарчмаар ажилласан.

ТХ, ТХБ, ТХЗ, ТБ-ын цогц чадамжийн чиглэлээр сүүлийн жилүүдэд ЮНЕСКО-оос гаргасан онол, арга зүйн удирдамжийн баримт бичиг, гарын авлагыг судалж улмаар “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилтууд (ТХЗБ)” (UNESCO, 2017) болон “Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан-Хүмүүс гараг дэлхийн төлөө боловсрол (БХШДТ)” (UNESCO, 2016) баримт бичгүүдийн онол, арга зүйд тулгуурлан тус судалгааны шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Бенчмаркийг шалгуур тус бүрээр өндөр, дунд, бага гэсэн 3 түвшинд авч үзсэн. Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг үнэлэхийн тулд цөм хөтөлбөрийн *зорилго, зорилт, үнэлгээг* 8 шалгуур, 26 индикатор (Хүснэгт 1-ийн 1-8-р мөр), *судлагдахууны агуулгыг* 4 шалгуур 29 индикатор (Хүснэгт 1-ийн 9-12-р мөр), *судлагдахууны арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг* 4 шалгуур 20 индикатор (Хүснэгт 1-ийн 13-16-р мөр) гэсэн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүрийг үнэлэх 4 төрлийн зориулалттай нийт 16 шалгуур, 75 индикатор бүхий EXCEL программ дээр суурилсан багаж, хэрэгслийг боловсруулан судалгаанд хэрэглэсэн.

Хүснэгт 1: Сургалтын цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг үнэлэх шалгуур ба индикаторууд, тэдгээрийн товчлол

№	СХ-ийн бүрэлдэхүүн	Шалгуур, товчлол	Индикатор
1	Зорилго, үнэлгээ	1. Тогтолцоот сэтгэлгээний цогц чадамж-ТСЦЧ	4
2		2. Урьдчилан тооцоолох цогц чадамж-УТЦЧ	5
3		3. Хэм хэмжээний цогц чадамж-ХХЦЧ	2
4		4. Стратегийн цогц чадамж-СЦЧ	2
5		5. Хамтран ажиллах цогц чадамж-ХАЦЧ	5
6		6. Шүүмжлэлт сэтгэлгээний цогц чадамж-ШСЦЧ	3
7		7. Өөрийгөө таньж мэдэх цогц чадамж-ӨТМЦЧ	3
8		8. Асуудал шийдвэрлэх нэгдсэн цогц чадамж-АШНЦЧ	2
9	Агуулга	1. Жендэрийн тэгш эрх-ЖТЭ	5
10		2. Хүний эрх –ХЭ	5
11		3. Тогтвортой хөгжил-ТХ	10
12		4. Дэлхийн иргэншил-ДИ	9
13	Арга, хэрэглэгдэхүүн	I. Бодит, хамтын үйл ажиллагаанд оролцох арга-БХАОА	7
14		II. Шинжилгээ/ судалгаа хийх арга-ШСА	5
15		III. Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэлгээ шаардсан арга-БШСА	4
16		IV. Алсын хараатай болох арга-АХА	4
		16	75

Ерөнхий хэсэг болон агуулга хэсгээс бусад шалгуур, индикаторыг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагыг бүтээх явцад тусгайлан боловсруулагдсан багаж, хэрэгсэл болох Матриц-1, Матриц-2 (цаашид М-2 гэх) -ыг (БМДИ, ШХА, & “ТХБ” төсөл, 2018, хуудсд. 134-137) үндэслэн тэмдэглэгдсэн сурах бичиг, бусад эх үүсвэр, эсвэл тухайн судлаачийн бодлоор тодорхойлогдсон байж болох боломжуудыг хасаж, цөм хөтөлбөр (ЦХ), суралцахуйн удирдамж

(СУ) хоёрыг дахин сайн нягтлаад орхигдсон зүйлийг нэмж бүртгэх зарчмаар ажилласан.

Хөтөлбөрийн зорилго, зорилт, үнэлгээнд. ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилго, зорилт, үнэлгээ нь Тогтвортой байдлын Цогц Чадамж (ТБЦЧ)-ийн төлөвшилд аль хэр хувь нэмэр оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлэхэд чиглэсэн. Тогтвортой байдлын Цогц Чадамж (ТБЦЧ)-ийг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.1. Цогц чадамж, Тогтвортой байдлын цогц чадамж” дэд бүлэгт орчуулан, дэлгэрүүлэн тайлбарласнаар хэрэглэсэн (БМДИ, ШХА, & “ТХБ” төсөл, 2018, хуудсд. 90-96). ЮНЕСКО-ийн “ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилт” баримт бичигт “Key competencies for sustainability” гэж томъёолон ТХ-ын төлөөх боловсролыг суралцахуйн бихеворист шинжийг илүү тодруулан өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн онцлогоос үл хамааран “дэлхийн хэмжээнд бүх насны суралцагчдад заавал төлөвшсөн байх” гэдэг утгаар хэрэглэсэн байна.

Хөтөлбөрийн агуулгад. Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан-2016 нь глобал үзүүлэлтүүдэд ихээхэн анхаарал хандуулсан ба ерөнхий тогтолцооны арга хэмжээ, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, түүнчлэн багшийг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт дэлхийн иргэний болон тогтвортой хөгжлийн боловсролыг ямар агуулга, хэлбэрээр оруулах боломжтой талаар глобал болон сэдэвчилсэн үзүүлэлт хүрээнд шалгуур индикаторуудыг санал болгон танилцуулж дүн шинжилгээ хийсэн байна. Энэхүү тайланд хүний эрх, жөндөрийн тэгш байдал, энх тайвныг эрхэмлэх соёл, хүчирхийллийг үл тэвчих байдал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маягийг дээшлүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар үндэсний сургалтын хөтөлбөрийн агуулгад тусгагдсан байдлыг үнэлэхэд чиглэжээ. Мөн хэсэг тус бүрт хамаарах 29 орчим нэр томъёо агуулга нь ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.3. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын сэдэв” дэд бүлэгт дурдсан ТХЗСЗ удирдамжид санал болгосон 17 зорилгын 171 сэдэв (БМДИ, ШХА, & “ТХБ” төсөл, 2018, хуудсд. 115-123)-тэй уялдуулах байдлаар харгалзуулсан.

Хөтөлбөрийн арга зүй, орчин хэрэглэгдэхүүнд. ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийн арга зүй, орчин хэрэглэгдэхүүн нь ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргуудад аль хэр хувь нэмэр оруулахаар тодорхойлогдсон байдлыг үнэлэхэд чиглэсэн. ТХЗ-ын төлөөх суралцахуйн түлхүүр аргуудыг “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагын “3.4. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын арга зүйн хандлага арга, техник” дэд бүлэг (БМДИ, ШХА, & “ТХБ” төсөл, 2018, хуудсд. 123-133)-т орчуулан, дэлгэрүүлэн тайлбарласнаар хэрэглэсэн. ЮНЕСКО-ын “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилтууд (ТХЗБ)” удирдамжид ТХЗ тус бүрээр сургалтын арга техникийн 7 жишээ, 17 зорилгоор нийт 119 жишээг өгсөн байна. “ТХБ-ыг ЕБС-ын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагааны арга зүй” (2018) гарын авлагыг боловсруулах явцад судлаачид эдгээр 119 сургалтын арга техникийн жишээг харьцуулан судалж, 20 тодорхой аргыг ялган төрөлжүүлэн, ТХЗ-ын сургалтын түлхүүр 4 аргын аль төрөлд хамаарах байдлаар тодорхойлсон байна. Боловсролын 3 түвшинд нийт 4 чиглэлийн 46 судлагдахуунаар үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг боловсруулсан.


Хүснэгт 2: Судалгаанд хамруулсан сургалтын цөм хөтөлбөр

Судлагдахууны чиглэл	Судлагдахуун	Анги
Математик, байгалийн ухаан (Мат, БУ)	Математик, Мэдээлэл зүй, Физик, Хими, Биологи, Газар зүй	1-12
Хэл хүмүүнлэгийн ухаан (Хэл, Х)	Монгол хэл, Уран зохиол, Үндэсний бичиг, Англи хэл, Орос хэл, Хөгжим, Дүрслэх урлаг, Эрүүл мэнд, Технологи, Биеийн тамир	1-12
Түүх нийгмийн ухаан (Түүх, Н)	Түүх	6-9
	Нийгмийн ухаан	7-12
Сургалтыг дэмжих үйл ажиллагаа (СДҮА)	Иргэний боловсролын, Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	1-9

Үр дүн

ЕБС-ийн бүх ангийн бүх судлагдахууны “Цөм хөтөлбөр”¹-т ТХБ-ын тусгагдсан байдлыг ТХЗБ-ын суралцахуйн зорилтууд, үнэлгээ, агуулга, арга, хэрэглэгдэхүүн тус бүрийн шалгуур индикатораар задлан шинжлэхэд давхардсан тоогоор нийт 5653 өгөгдөл бүртгэгдсэн ба тэдгээрийн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд харгалзах тоог Зураг 1-д үзүүллээ.

Зураг 1: ЕБС-ийн “Цөм хөтөлбөр”-т ТХЗБ-ын тусгагдсан ерөнхий байдал (давхардсан нийлбэр тоогоор)



Зураг 1-ээс харахад “Цөм хөтөлбөр”-өөс бүртгэгдсэн нийт өгөгдлийн 22.3% хөтөлбөрийн зорилго, зорилтод, 7.4% үнэлгээнд, 12.8% агуулгад, 33.1% аргад, 24.4% орчин ба хэрэглэгдэхүүнд тус тус ногдож байна. “Цөм хөтөлбөр”-т үнэлгээний зорилт нь суралцахуйн зорилтоосоо 3 дахин цөөн байна. Зүй ёсоороо бол үнэлгээний зорилт (шалгуур, индикаторууд) нь хөтөлбөрийн зорилтоосоо дутуугүй, харин ч илүү байх учиртай.

Мөн сургалтын арга зүй буюу арга ба хэрэглэгдэхүүнд хамаарах өгөгдлүүд нийт өгөгдлийн 57.5% эзэлж байгаа бөгөөд арга нь хэрэглэгдэхүүнээсээ 1.4 дахин олон байна. Энэхүү судалгаагаар “Цөм хөтөлбөр”-ийн арга зүйн хэсэг нь өндөр үзүүлэлттэй гарч байгаа нь Үндэсний сургалтын цөм хөтөлбөрт арга зүйн хэсэг нь хэт ерөнхий тусгагдсан байсан тул үнэлгээнд Суралцахуйн удирдамжуудыг нэмж хамруулан үзсэнтэй холбоотой гэж үзэж болно. Учир нь Суралцахуйн удирдамжид арга зүйг нарийвчлан тайлбарласан байдаг.

1 “Цөм хөтөлбөр” гэдгийн доор М-2, Үндэсний цөм хөтөлбөр, Суралцахуйн удирдамжийг тус тус багтаан ойлгоно.

“Цөм хөтөлбөр”-ийн агуулга нь бусад бүрэлдэхүүн хэсгээсээ хамгийн бага буюу 12.8% байгаа нь энэхүү судалгаанд ТХЗБ-д санал болгосон 17 зорилгод харгалзах 171 сэдвийг бус ЮНЕСКО-ийн 2016 оны “Дэлхий нийтийн хяналт-шинжилгээний илтгэл”-д сургалтын хөтөлбөртөө ТХБ-ын агуулгын интеграцчилсан байдлыг харьцуулан үнэлэхэд хэрэглэсэн нийт 4 төрлийн 29 индикаторыг хэрэглэсэнтэй холбоотой.

ЕБС-д судалдаг 4 төрөлд ангилсан бүх судлагдахууныг хамруулж, “М-2” болон “Цөм хөтөлбөр”-өөс ТБЦЧ-ын 8 ай бүхий 26 индикатораар илрүүлсэн 1259 хөтөлбөрийн зорилго зорилт ба 420 үнэлгээний статистикаас харахад дараах ерөнхий дүр зураг ажиглагдаж байна (Хүснэгт 3).

1. Бүх бүлэг хичээлийн судлагдахуун бүрийн М-2 болон ЦХ-ийн зорилгод харгалзах чадвар (нийлбэр)-ын тоо нь тэдгээрийн ЦХ-ийн үнэлгээнд тодорхойлогдсон чадварын тооноос 1.3-1.7 дахин олон байна.
2. Тухайн судлагдахууны зорилгод тусгаж, ТБЦЧ-д хувь нэмэр оруулна гэж бүртгэгдсэн чадварууд (нийлбэр) харьцангуй олон байна. Өөрөөр хэлбэл, түүх, нийгмийн ухаанаас бусад бүх бүлэг хичээлийн судлагдахуун бүрд 2-5 чадвар бүртгэгджээ гэж үзэж болохоор байна.
3. Математик, байгалийн ухаан болон хэл хүмүүнлэгийн бүлэг хичээлүүдэд бүртгэгдсэн чадварууд ТБЦЧ-ийн төлөвшилд бусдаасаа илүү хувь нэмэр оруулахаар олон тоотой бас харьцангуй жигд тархалттайгаар тодорхойлогдсон байна.
4. ТБЦЧ-ын 8 ай бүхий 26 индикаторуудад харгалзах чадварууд бүх бүлэг хичээлүүдэд харьцангуй жигд тархалттай байгаа боловч дараах онцлогууд ажиглагдаж байна. Үүнд:
 - a. ЦХ-ийн үнэлгээнд түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн хувьд бүртгэгдсэн чадварууд болон тэдгээрийн илэрсэн судлагдахууны статистик хазайлт харгалзан өндөр (1.2 ба 1.5 болон 0.5 ба 0.6) байна. Энэ нь ТБЦЧ-ийн СЦЧ, ХАЦЧ, ШСЦЧ, УТМЦЧ, АШЦЧ айн чадварууд бараг бүртгэгдээгүйтэй холбоотой байна.
 - b. Түүнчлэн ТСЦЧ-ын тодорхойгүй байдлыг авч үзэх чадвар (1.4) бүлэг хичээлүүдийн аль ч судлагдахуунд мөн ХХЦЧ-ын “тогтвортой байдлын үнэт зүйл, зарчим, зорилго,

зорилтын талаар ашиг сонирхлын зөрчилтэй, харилцан ашигтай, тодорхойгүй мэдлэг чадвартай, эсэргүүцэлтэй тулгарсан нөхцөл байдалд ч хэлэлцээр хийх чадвар” (3.2) хэл хүмүүнлэгээс бусад хичээлд огт бүртгэгдээгүй байна.

ТХБА-ыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх аргыг үнэлэхдээ “М-2”, “Цөм хөтөлбөр” болон “Суралцахуйн удирдамж”-д интеграцчилагдсан байдлыг шинжилсэн. Энэ шинжилгээний үр дүнгийн статистикаас харахад ТХЗБ-ын 4 айн 20 индикатораар илэрсэн арга техникүүд нь бүх бүлэг хичээлийн бараг бүх судлагдахуунд бүртгэгдсэн тархалттай байгаа боловч тэдгээрийн давтамж нь нэлээд ялгаатай байна. (Хүснэгт 4). Тухайлбал,

1. Хэдийгээр бүлэг хичээлүүдийн хувьд судлагдахууны тоо болон аргуудын айнуудад харгалзах индикаторуудын тоо бага зэрэг ялгаатай боловч М-2 ба ЦХ ба СУ-аас бүртгэгдсэн БХАОА айд хамаарах “үйл ажиллагаанд оролцох, хамрагдах, төлөвлөх” (I.5), “үйл ажиллагааны төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, оролцох” (I.6) аргууд; ШСА айд хамаарах “задлан шинжилгээ, судалгаа хийх” (II.1), “тохиолдлын шинжилгээ хийх” (II.2), туршилт хийх (II.4) аргууд; түүнчлэн БШСА айд хамаарах “эсээ бичих, хэлэлцүүлэг хийх” (III.1) арга нь математик, байгалийн ухаан болон хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлд тус тус бусад индикаторуудтай харьцуулахад илүү өндөр давтамжтай байна.
2. Харин түүх, нийгмийн ухааны бүлэг хичээл болон СДҮА-уудад ШСА айн “туршилт хийх” (II.4), БШСА-айн “вэб, блог хөтлөх, видео клип хийх” (III.4), АХА айн “түүх намтар зохиох” (4.2), “ирээдүйд тодорхой нөхцөлд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах” (IV.3), “үзэл баримтлал, зарчим боловсруулах” (IV.4) аргууд огт бүртгэгдээгүй байна.
3. Математик, байгалийн ухаан болон Хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд СУ-аас бүртгэгдсэн аргын (харгалзан 36 ба 29) тоо ЦХ-өөс бүртгэгдсэн аргын тоо (харгалзан 54 ба 66)-оос илүү олон байна. Энэ нь цаашид цөм хөтөлбөрийг боловсронгуй болгохдоо арга зүйн хэсгийн шийдлийг оновчлох шаардлагатайг харуулж байна.

М-2, ЦХ, СУ-аас бүртгэгдсэн аргуудыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдэх орчин ба хэрэглэгдэхүүн (цаашид хэрэглэгдэхүүн гэнэ)-ний тархалт ба давтамжийн шинжилгээний үр дүнгийн статистикаас харахад ТХЗБ-ын 4 айн 20 индикаторуудад харгалзах арга техникүүдийг хэрэгжүүлэхэд ашиглагдах сургалтын хэрэглэгдэхүүнүүд нь бүх бүлэг хичээлийн бараг бүх судлагдахуунд бүртгэгдсэн боловч тархалт нь харьцангуй жигд бус давтамж нь нэлээд ялгаатай байна (Хүснэгт 5). Тухайлбал,

1. Түүх, нийгмийн ухааны бүлэг хичээлийн тухайд шинжилгээнд суурилсан төсөл (enquiry-based project) (II.3) ба туршилт хийх (II.4) аргыг хэрэгжүүлэхэд ашиглагдах нэг ч хэрэглэгдэхүүн М-2 ба ЦХ-өөс мөн дүрд хувилан тоглох (III.2), экскурс, танилцах аялал (3.3), вэб, блог хөтлөх, видео клип хийх (3.4); түүх намтар зохиох (IV.2), ирээдүйд тодорхой нөхцөлд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах (IV.3), үзэл баримтлал, зарчим боловсруулах (IV.4) аргад тус тус хэрэглэгдэх нэг ч хэрэглэгдэхүүн М-2-оос тус тус бүртгэгдээгүй байна.
2. Математик, байгалийн ухаан болон хэл хүмүүнлэгийн ухааны бүлэг хичээлийн тухайд ТХЗБ-ын аргын бүх айн аргуудад хэрэглэгдэх хэрэглэгдэхүүнүүд бүртгэгдсэн бөгөөд тэдгээр нь М-2, ЦХ, СУ-ын аль алинд нь харьцангуй өндөр давтамжтай байна. Эдгээр бүлэг хичээлийн хувьд нийт дүнгээрээ СУ (65)-д ЦХ (35)-өөс илүү олон хэрэглэгдэхүүн бүртгэгдсэн байна. Энэ нь СУ-д сургалтын арга зүй илүү нарийвчлалтай тодорхойлогджээ гэдгийг харуулж байна.

Дүгнэлт, хэлэлцүүлэг

2014 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөж буй бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр бүхэлдээ шинжлэх ухааны мэдлэг, чадвараас гадна өөрийн хүч нөөцийг мэдрэх, бусадтай хамтрах, мэдлэгийг эрж хайх олж судлах арга барилтай болох, байнга тасралтгүй хөгжих, хүрээлэн буй орчныг зөв ухаарч тэнд өөрийгөө зөв авч явах, зорилго чиглэлтэй амьдарч хөдөлмөрлөх зэрэг хувь хүний хөгжилд хандсан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг харьцангуй сайн тусгаж чадсан байна.

Цөм хөтөлбөрийн агуулгад ТХЗБ-ын “Жендэрийн тэгш эрх”, “Хүний эрх”, “Тогтвортой хөгжил”, “Дэлхийн иргэншил” гэсэн агуулгын 4 айн “Тогтвортой хөгжил” айн агуулга бүх судлагдахууны хувьд бусад айнаасаа олон дахин илүү бүртгэгдсэн нь 2002 оноос хойш ТХ ба ТХБ-ыг боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөрт интеграцчилах стратегийг тууштай баримталж ирсний нэг тод илрэл юм.

Боловсролд ТХБ буюу ТХЗБ-ын интеграцчилах тусгайлсан арга зүй байх нөхцөлд тэдгээрийг хөтөлбөрт интеграцчилах боломж эрс нэмэгдэж болохыг монгол хэл бичгийн суурь болон бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрт хийсэн шинжилгээний үр дүнгийн ялгаа тод харуулж байгааг судлаачид тэмдэглэсэн байна. Тухайлбал, монгол хэл бичгийн бүрэн дунд боловсролын хөтөлбөрт бүртгэгдсэн зорилго, суралцахуйн зорилтууд нь суурь боловсролын хөтөлбөрийнхөөс илүү өргөн тархалт ба өндөр давтамжтай байгааг уг хөтөлбөрийг боловсруулах үед (2016 он) боловсролд ТХБ-ыг интеграцчилах арга хандлага тодорхой болж, олон улсын туршлагаас суралцах боломж нэмэгдсэнтэй холбоотойгоор тайлбарлажээ.

Хүснэгт 3: “Цөм хөтөлбөр”-ийн зорилго ба үнэлгээнд ТБЦЧ-ийн интeгpaциллагдсан байдлын статистик (чaдeар бa судлaгдaхууны тoо)

№	Шалгуур	Зорилго М-2						Зорилго ЦХ						Үнэлгээ ЦХ											
		Нийлбэр			судлагдахуун			Нийлбэр			судлагдахуун			Нийлбэр			судлагдахуун								
		Мат. Бү	Түүх, Н	СДҮА	Мат. Бү	Түүх, Н	СДҮА	Мат. Бү	Түүх, Н	СДҮА	Мат. Бү	Түүх, Н	СДҮА	Мат. Бү	Түүх, Н	СДҮА	Мат. Бү	Түүх, Н	СДҮА						
		<i>i</i>	<i>ii</i>	<i>iii</i>	<i>iv</i>	<i>v</i>	<i>vi</i>	<i>vii</i>	<i>viii</i>	<i>ix</i>	<i>x</i>	<i>xi</i>	<i>xii</i>	<i>xiii</i>	<i>xiv</i>	<i>xv</i>	<i>xvi</i>	<i>xvii</i>	<i>xviii</i>	<i>xix</i>	<i>xx</i>	<i>xxi</i>	<i>xxii</i>	<i>xxiii</i>	<i>xxiv</i>
1	1.	27	31	8	15	5	5	2	3	23	17	6	8	6	4	2	3	18	11	4	10	5	4	2	3
2	ТСЦЧ	12	3	0	2	4	2	0	1	7	2	1	2	3	1	1	1	9	3	0	1	4	2	0	1
3		23	1	2	4	4	1	1	1	5	0	2	1	3	0	1	1	8	0	2	1	4	0	1	1
4		0	2	0	1	0	1	0	1	2	0	1	0	1	0	1	0	4	0	4	3	2	0	1	1
5	2.	15	6	1	0	3	2	1	0	7	4	1	0	3	1	1	0	5	6	4	1	2	3	1	1
6	УТЦЧ	7	10	4	4	3	2	2	1	2	5	5	1	1	2	2	1	6	4	3	3	2	2	1	2
7		27	19	3	4	4	4	1	1	9	11	2	1	5	3	1	1	2	3	4	1	1	1	1	1
8		16	9	2	1	3	3	1	1	8	10	4	2	4	4	2	1	9	14	3	1	3	4	1	1
9		7	4	0	1	3	2	0	1	6	2	0	0	2	1	0	0	9	7	2	1	4	2	1	1
10	3.	19	31	2	3	5	6	1	1	7	20	2	3	2	5	1	1	8	15	2	3	2	5	1	1
11	ХХЦЧ	0	1	0	0	1	0	0	1	1	1	0	1	1	1	1	0	2	1	0	1	1	1	0	1
12	4.	21	9	2	4	5	1	1	1	5	4	2	2	2	1	1	1	5	7	0	0	2	1	0	0
13	СЦЧ	1	0	1	2	1	0	1	1	2	0	2	1	2	0	1	1	3	0	0	2	3	0	0	2
14	5.	11	22	4	5	3	4	1	2	9	8	2	5	4	4	1	2	3	6	1	5	2	5	1	2
15	ХАЦЧ	6	15	3	7	3	3	1	3	4	7	2	6	3	3	1	3	4	6	0	8	2	4	0	3
16		26	8	6	1	4	1	2	2	13	4	3	2	4	1	1	1	14	0	1	1	4	0	1	1
17		5	19	3	7	2	3	1	2	4	7	2	4	2	3	1	2	5	5	0	2	4	2	0	1
18		8	6	4	6	2	3	1	2	2	3	1	3	1	2	1	2	3	7	0	3	2	3	0	1
19	6.	9	8	8	3	3	2	2	2	7	3	2	2	2	1	1	1	4	1	0	1	2	1	0	1
20	ШСЦЧ	14	21	4	6	4	7	1	1	11	17	3	4	4	6	2	2	6	11	1	0	2	5	1	0
21		5	13	2	1	2	4	1	1	3	11	0	3	2	5	0	1	5	11	0	1	3	5	0	1

Хүснэгт 5: “Цөм хөтөлбөр”-ийн арга зүйд ТХЗБ-ын аргуудын интеграцчиллагдсан байдлын статистик (чадавар ба судлагдахууны тоо)

№	Шангуур	Индикатор	Арга, М-2						Арга, ЦХ						Арга, УДР											
			Нийлбэр			судлагдахуун			Нийлбэр			судлагдахуун			Нийлбэр			судлагдахуун								
			Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДҮА	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДҮА	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДҮА	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДҮА	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДҮА				
1	I.	I.1.	i	ii	iii	iv	v	vi	vii	viii	ix	x	xi	xii	xiii	xiv	xv	xvi	xvii	xviii	xix	xx	xxi	xxii	xxiii	xxiv
2		I.2.	6	1	5	11	2	1	1	3	2	1	1	1	1	1	1	3	3	6	4	8	1	3	2	2
3		I.3.	3	4	6	14	2	1	2	3	2	2	4	9	1	1	1	3	5	6	3	8	3	2	1	2
4		I.4.	0	2	3	2	0	1	1	1	3	3	3	3	2	1	1	1	1	1	3	2	3	1	1	1
5		I.5.	4	19	0	1	1	3	0	1	7	19	1	1	2	4	1	1	6	66	0	0	2	4	0	0
6		I.6.	27	34	11	8	5	5	1	2	18	25	5	8	3	4	1	2	16	30	4	7	3	6	2	2
7		I.7.	9	25	7	6	4	4	1	2	14	13	2	7	4	4	1	2	14	17	2	7	3	4	1	2
8		II.1.	6	7	3	1	3	3	1	1	8	5	2	0	6	2	1	0	24	14	3	1	4	3	1	1
9		II.2.	78	52	9	2	6	7	1	2	36	23	3	3	6	7	1	2	54	45	3	1	5	7	1	1
10		II.3.	26	8	9	2	4	1	1	2	12	8	4	2	3	1	1	2	17	22	7	2	4	2	1	1
11		II.4.	11	6	2	1	3	1	1	1	11	4	2	2	3	1	1	1	9	8	4	0	3	3	1	0
12		II.5.	20	16	0	0	3	3	0	0	19	7	0	0	4	1	0	0	27	13	0	0	3	2	0	0
13		III.1.	3	3	6	3	2	2	1	2	2	3	2	4	2	1	1	2	3	5	4	4	2	1	1	2
14		III.2.	22	45	14	5	4	8	2	3	16	29	3	3	5	9	1	1	25	35	5	5	5	9	2	2
15		III.3.	3	19	8	0	1	4	2	0	4	12	4	0	1	3	1	0	5	23	2	0	1	4	1	0
16		III.4.	13	7	7	5	4	3	2	2	9	6	3	8	2	3	1	2	11	13	2	6	3	6	1	2
17		IV.1.	0	1	2	1	0	1	1	1	4	5	0	0	3	2	0	0	5	4	1	0	3	3	1	0
18		IV.2.	6	6	3	2	2	3	1	1	10	6	2	1	2	3	1	1	4	9	3	2	2	4	1	2
19		IV.3.	4	3	1	0	1	1	1	0	3	3	0	0	2	1	0	0	1	4	0	0	1	2	0	0
20		IV.4.	18	9	4	0	4	3	1	0	14	7	3	0	3	2	1	0	12	10	3	0	3	3	1	0
		Дискриптив	3	3	0	0	3	3	0	0	4	1	1	0	2	1	1	0	2	3	2	0	1	2	1	0
		max	78	52	14	14	6	8	2	3	36	29	5	9	6	9	1	3	54	66	7	8	5	9	2	2
		min	0	1	0	0	0	1	0	0	2	1	0	0	1	1	0	0	1	3	0	0	1	1	0	0
		ave	13.1	13.5	5.0	3.2	2.7	2.9	1.1	1.4	9.9	9.1	2.3	3.0	2.9	2.6	0.9	1.2	12.2	16.8	2.7	2.7	2.7	3.6	1.0	1.0
		SD	17.0	14.5	3.8	3.8	1.6	1.9	0.6	1.0	8.1	8.2	1.4	3.3	1.5	2.1	0.4	1.0	12.5	16.0	1.7	3.0	1.2	2.0	0.5	0.9

Хүснэгт 6: “Цөм хөтөлбөр”-ийн арга зүйд сургалтын хэрэглэгдэхүүний интеграцчлагдсан байдлын статистик (цадвар ба судлагдахууны тоо)

Эн	Шалгуур	Орчин хэрэглэгдэхүүн, М-2						Орчин хэрэглэгдэхүүн, ЦХ						Орчин хэрэглэгдэхүүн, УДР																															
		Нийлбэр		Судлагдахуун		Индикатор		Нийлбэр		Судлагдахуун		Индикатор		Нийлбэр		Судлагдахуун		Индикатор																											
		Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДГА	И	II	III	IV	V	VI	VII	VIII	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДГА	IX	X	XI	XII	XIII	XIV	Мат. БУ	Хэл, Х	Түүх, Н	СДГА	XV	XVI	XVII	XVIII	XIX	XX	XI	XXII	XXIII	XXIV								
1		5	0	1	5	2	0	1	2	2	0	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	3	1	4	1	1	1	1	1	1	1	1	1	1	2								
2		4	0	1	6	2	0	1	2	2	0	1	2	2	2	1	5	1	1	2	2	2	2	8	2	1	5	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	2						
3		1	0	2	1	0	1	0	1	0	1	0	1	1	0	3	1	0	1	1	1	1	1	2	1	3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1					
4	БХГАОА	1	17	0	1	1	2	0	1	10	15	0	1	3	3	0	1	3	3	0	1	16	35	0	1	2	3	0	1	2	3	0	1	2	3	0	1	2	3	0	1				
5		13	33	7	4	3	3	1	2	5	19	5	6	3	3	2	3	23	15	4	4	2	10	12	4	3	2	3	1	2	2	3	1	2	2	3	1	2	2	3	1	2			
6		2	14	3	3	1	2	1	2	4	7	4	4	2	2	2	2	2	2	2	2	10	12	4	3	2	3	1	2	2	3	1	2	2	3	1	2	2	3	1	2				
7		5	8	1	2	2	2	1	1	7	6	3	2	5	3	1	1	26	12	3	2	4	3	1	1	26	12	3	2	4	3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
8		69	32	1	1	5	5	1	1	16	22	3	5	6	5	1	2	65	22	6	3	4	4	2	1	65	22	6	3	4	4	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
9		15	7	1	0	5	1	1	0	4	7	4	0	3	1	1	0	21	16	3	0	4	1	1	0	21	16	3	0	4	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
10	ШХУА	6	3	0	0	2	1	0	0	4	2	0	1	3	1	1	1	10	6	0	3	2	0	1	10	6	0	3	2	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
11		30	5	0	0	3	1	0	0	11	3	0	0	5	1	0	40	9	0	0	0	4	1	0	40	9	0	0	4	1	0	0	0	4	1	0	0	4	1	0	0	4	1	0	
12		4	1	1	1	2	1	1	1	2	2	3	1	1	1	1	1	4	3	2	1	2	1	1	4	3	2	1	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
13		14	32	3	3	3	5	1	2	8	20	6	3	4	5	1	35	27	5	3	4	5	1	35	27	5	3	4	5	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2		
14		3	15	0	0	1	2	0	0	4	10	0	0	1	3	0	0	6	20	0	0	6	20	0	0	6	20	0	0	1	3	0	0	1	3	0	0	1	3	0	0	1	3	0	0
15	БШССША	12	0	0	3	4	0	0	2	16	6	1	4	2	2	2	2	23	9	1	3	2	2	1	23	9	1	3	2	2	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	
16		0	3	0	1	0	1	0	1	4	2	2	0	3	2	1	0	2	4	2	0	4	2	0	4	2	0	4	2	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
17		5	5	3	0	2	2	1	0	6	3	2	0	2	1	1	0	9	3	3	0	2	1	0	9	3	3	0	2	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
18		1	3	0	0	1	1	0	0	2	3	0	0	1	1	0	0	2	3	0	0	2	3	0	0	2	3	0	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
19	АХБА	17	2	0	0	3	1	0	0	13	1	1	0	2	1	1	0	19	2	2	0	2	2	0	19	2	2	0	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	
20		2	2	0	0	2	2	0	0	2	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	0	1	0	
	max	69	33	7	6	5	5	1	2	16	22	6	6	6	6	5	2	3	65	35	6	5	4	5	65	35	6	5	4	5	4	5	4	5	4	5	4	5	4	5	4	5	4	5	4
	min	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	ave	10.5	9.1	1.2	1.6	2.3	1.6	0.6	0.9	6.1	6.7	2.0	1.9	2.5	2.0	1.0	1.0	16.3	10.1	2.0	1.7	2.3	2.0	0.8	16.3	10.1	2.0	1.7	2.3	2.0	0.8	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9	0.9
	SD	15.3	10.9	1.7	1.8	1.3	1.4	0.5	0.8	1.4	1.6	1.8	2.1	1.6	1.3	0.7	0.9	15.8	9.5	1.8	1.7	2.1	1.1	1.2	15.8	9.5	1.8	1.7	2.1	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2	1.1	1.2

Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн интеграцчилагдаж чадсан ч боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийн бүтэц, дизайны ялгаатай байдал, судлагдахууны агуулгын чиглэлүүдийн онцлогууд, хөтөлбөрүүдийн боловсруулалтын жигд бус байдал зэрэг нь хэрэглэгчдэд ойлгомжгүй, төвөгтэй байдлыг бий болгож байгааг тэмдэглэх шаардлагатай.

Байгалийн ухааны (хими, биологи, физик, газарзүй) хичээлийн цөм хөтөлбөрт арга зүй, орчин ба хэрэглэгдэхүүн, үнэлгээний зарчмыг нэгдсэн байдлаар хэт ерөнхий тодорхойлсон явдал нь зарим талаар судлагдахуун тус бүрийн онцлогийг харах боломжийг хязгаарлаж, тэдгээрийг тусгайлан судлахын ач холбогдол, үүрэг зориулалтыг бүдгэрүүлж байна.

Сургалтын арга болон хэрэглэгдэхүүний хувьд байгалийн ухааны цөм хөтөлбөрүүдэд ижилхэн бичигдсэн байхад судлаачид тэдгээрийг өөр өөрөөр бүртгэж тоолсон байдал харагдсан. Энэ нь *нэг талаас*, тухайн үзүүлэлтийг аль ч талаас нь харж болохоор хэт ерөнхий томъёологдсон нь хэмжигдэх, үнэлэгдэх боломжийг хязгаарласантай *нөгөө талаас*, судлаачдын мэдлэг, чадварын ялгаатай байдалтай тус тус холбоотой байж болохыг харуулж байна.

Бүх түвшний бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, сургалтын хөтөлбөр боловсруулагчид, үнэлгээний экспертүүд, арга зүйчид, сургуулийн удирдлагууд, ялангуяа судлаачид, багш нар энэ шинэ судлагдахууныг судалж, ТХ/ТХБ/ТХЗ/ТБ-ын цогц чадамжийн хэл ухагдахуунд нэн түрүүнд тайлагдаж, ойлголтын зөрөөгөө багасгах шаардлага үүсэж байна.

Сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгүүдээ хэрэгжүүлэх, сайжруулахдаа юуны өмнө зориулалтын багаж хэрэгсэл бүхий тусгай арга зүй боловсруулах цогц судалгааг чанарын баталгаа хангахуйц бодит хугацаатай байхаар төлөвлөн явуулах шаардлагатай.

Тусгайлсан төлөвлөгөө, менежментийн дагуу хүний нөөцөө чадавхжуулах зайлшгүй хэрэгцээ байна. Хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг зөвхөн олон хэлбэрээр давтан сургах бус, ТХБ-ын арга хандлагыг хэрэглэж, хүн

бүрийг “суралцагч” хэмээн үзэж, олон төрлийн бүх хэлбэрийн тодорхой үйл ажиллагаанд татан оролцуулж, бүтээлч үйлээр нь дамжуулан чадавхжуулах шаардлага байна.

Хязгаарлагдмал тал

Тус судалгаа нь хэрэгжүүлэх хугацаа, батлагдсан дизайн зэргээс хамаарч дор дурдсан хязгаарлалттай байна.

1. Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжид ТХБ-ын интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны тусгайлсан багаж, хэрэгсэл, болон 2015 оноос хойш ТХ, ТХБ-ын чиглэлээр гарсан ЮНЕСКО-ын баримт бичиг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны материалуудад төвлөрсөн.
2. Сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцчилагдсан байдлыг илрүүлэх судалгааны объектыг 2018 оны байдлаар ерөнхий боловсролын сургуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж гэсэн үндсэн 2 төрлийн баримт бичгүүдээр хязгаарласан.

Ном зүй

UNESCO. (2016). Global Education Monitoring Report: Education for people and planet.

UNESCO. (2017). Education for Sustainable Development Goals: Learning Objectives. Paris: UNESCO.

БМДИ, ШХА, & “ТХБ” төсөл. (2018). Тогтвортой хөгжлийн төлөө боловсролыг хувирган өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн хичээл, үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй (гарын авлага). УБ.

БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр.

БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр.

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Биологи).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Газар зүй).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Математик).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Монгол хэлбичиг, уран зохиол).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Мэдээлэл зүй).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Физик).

БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр (Хими).

Result of the research on the ideology, content, and methodology of sustainable development embodied in the core curriculum of general education

Ch.Nyamgerel^{1*}, N.Nergui², E.Shinetssetseg³, A.Tuya⁴

¹NUM, School of Arts and Sciences, *nyamgerel@num.edu.mn*

²"Tegsh Tavan Ukhaan" Public Service NGO,

³"Environmental Information and Training Center" Public Service NGO,

⁴MSUE, Teacher Development Center

Abstract

The global vision for education is changing, and focusing on embodying ESD concepts in curricula and study guidelines, and on developing citizens with ESD. But this is not an easy task. In this study, we used the document research methodology to evaluate the ideology and content of sustainable development embodied in the school curriculum by 16 criteria and 75 indicators within 3 sets. The results of the studies were reported in four sections of the subjects: Mathematics, Natural Sciences, Linguistics, History, Social Sciences, and Learning Support Activities. Also, they were developed by primary, basic, and upper secondary education levels, and by each component of the curriculum. In the survey, 5,653 duplicate data were recorded, 22.3% of the total data recorded is related to the goals and objectives of the curriculum, while 7.4% is related to the evaluation, 12.8% to the content, 33.1% to the teaching methodology, and 24.4% to the learning environment and tools. The data related to the teaching methodology and tools accounted for 57.5% of the total data, and it is namely 1.4 times more than the tools. It is maybe caused by the Learning Guidelines covered additionally in the study for more detailed clarification, due to the methodological part of the national core curriculum was very general. The core curriculum of primary and basic education implemented since 2014, is focused not only on scientific knowledge and skills but also is embodied well the

ideology and content of ESD for individual development such as experiencing one's resources, collaborating with others, seeking knowledge, and working&living purposefully.

Keywords: Sustainable development, Sustainable development goals, Sustainability competency, Education for Sustainable Development, Education for Sustainable Development Goals, Core Curriculum.